

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ

Г.Түмэннаст багш, докторант

МУИС, НШУС, Социологийн тэнхим

Товч агуулга: Нийгмийн хамгааллын харьцуулсан судалгааны талбарт нэр бүхий барууны судлаачдын хэв маягчлалын талаар өгүүлэх ба хилийн чанад дахь нийгмийн хамгаалалт төрийн англи саксоны, эх газрын европын, умардын зэрэг хэв маягуудыг шалгуур үзүүлэлтийн тусламжтайгаар дүрслэн үзүүлэхийг зорьсон байна. Ингэхдээ нийгмийн хамгаалалт төрийн хэв маягчлал нь орчин үеийн нийгмийн хамгааллын харьцуулсан судалгааны хөгжилд хүчтэй нөлөөлсөн болохыг тэмдэглэсэн болно.

Түлхүүр ойлголтууд: Нийгмийн хамгаалалт төр (Welfare state), Нийгмийн хамгаалалт төрийн хэв маяг (Type of welfare state), Харьцуулсан нийгмийн хамгаалал судлал (comparative research of welfare), Нийгмийн хамгаалалт капитализм (welfare capitalism), Зах зээлийн ширвэлтээс хамгаалах (Dekommodification) болон нийгмийн баялаг хуваарилах чадавхи (Umverteilungskapazitaet), Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг оршин суугчдад хүргэхийг чухалчлах (Residualism for welfare), Нийгмийн хамгааллын салбарын хувьчлал (Privatization of welfare), Төрийн чиг үүргийг дээдлэх үзэл (Etatismus) ба корпоратизм (Korporatismus), Бүрэн ажил эрхлэлтийг баталгаажуулах (full employment guarantee)

Нийгмийн хамгаалалт төр⁵⁶ хэмээх нь төр, засгийн газрын зүгээс хүн амын нийгмийн баталгааг хангах бодлого, үйл ажиллагаа, түүний төлөө бүрдүүлж байгаа тогтолцоог бүхэлд нь хамарсан өргөн хүрээтэй ойлголт билээ. Нийгмийн хамгаалалт төрийн харьцуулсан судалгааны загалмайлсан эцэг Э.Андерсен⁵⁷ өөрийн "Нийгмийн хамгаалалт капитализмын гурван ертөнц" хэмээх алдарт бүтээлдээ барууны капиталист орнуудын хүн амын нийгмийн хамгааллын асуудлыг төрийн зүгээс шийдвэрлэж байгаа арга, механизм, институцчилалд дүн шинжилгээ хийж ерөнхийдөө гурван үндсэн хэв маягыг бүрдүүлж байгаа гэсэн дүгнэлтэнд хүрсэн байна. (Р.Гүүдин болон бусад, 1999, 11-12) Тэрээр нийгмийн хамгааллын хүрээнд төрөөс явуулж байгаа бодлого, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийхдээ юуны өмнө тодорхой хэв маягуудыг үүсгэх шалгуур үзүүлэлтийн системийг бүрдүүлэхэд анхаарлаа хандуулжээ. Э.Андерсен асуудалд гурван шалгуур үзүүлэлтээр хандсан нь нэгдгээрт,

⁵⁶ Уг ойлголтын уг сурвалж, агуулга, мөн чанарын талаар Г.Түмэннаст. "Нийгмийн хамгаалалт төрийн судалгааны онол аргазүйн зарим асуудал" МУИС. Политологи Сэтгүүл. №5 УБ 2009 өгүүллээс үзнэ үү.

⁵⁷ Нийгмийн хамгаалалт капитализмын ертөнц (world of welfare capitalism) хэмээх хэллэгийг халамжлагч төрийн дэглэмүүдийн мөн чанарыг илэрхийлэх үүднээс Э.Андерсен анх оруулж ирсэн болов ч, түүнээс өмнө иймэрхүү санаа судлаачдын дунд нэлээдгүй оршин байсан гэж үздэг.

тухайн улсад төрийн буюу нийтийн халамж, хамгаалал, гэр бүл, төрөл садны тусламж, дэмжлэг, зах зээл буюу хувийн хэвшлээс бүрэлдэж буй хамгааллын үйлчилгээ гурвын холимог харилцаа ямар байдалтай байгаа, **хоёрдугаарт**, төрөөс хүн амын суурь баталгааг зах зээлээс үл хамаарсан байдлаар бүрдүүлэх буюу ажиллах хүчний бараа, таваар мэт арилжигдах шинжийг хязгаарлах бодлого ямар түвшинд байгаа, өөрөөр хэлбэл хөдөлмөрийн зах зээлийн орлого болон нийгмийн хамгааллыг хүчтэй тусгаарлах зарчим, **гуравдугаарт**, нийгмийн бодлого буюу төрийн интервенцээр дамжуулан нийгмийн социаль бүтцэд үзүүлж буй нөлөөлөл, өөрөөр хэлбэл нийгмийн тэгш бус байдлыг багасгах, гэтлэх зорилго бүхий арга хэмжээ, үйлчилгээ ямар түвшинд байгаа зэрэг байжээ. (Г.Базкер, Г.Наэгл болон бусад, 2005, 50-51)

Дээрх гурван үндсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд нарийвчилсан хэмжигдэхүүнийг буй болгож нийгмийн хамгаалалт төрийн гурван өөр дэглэмийн буюу хамгаалалт капитализмын гурван ертөнцийн талаарх зураглалыг бүтээсэн байна. (хүснэгт 1-ээс харна уу) Түүний тодорхойлсон гурван ертөнц бол **умардын, эх газрын европын, англи саксоны** нийгмийн хамгаалалт төр, улсууд болно. Ингэхдээ умардынх нь нийгмийн хамгаалал, хангамжийн универсаль үйлчилгээ, зах зээлийн ширвэлтээс үл хамааруулах хоёрын хольцоор, харин эх газрын европынх нь статусын ялгаанд, түүний тэгш бус байдалд тулгуурласан хамгааллын хүчтэй тогтолцоо бүрдүүлэх, хөдөлмөр эрхлэлтэнд баримжаалсан баталгааны зарчимд, түүнчлэн орон нутгийн хамгааллын чиг үүрэг буюу сүбсидиаризмаар, харин англи саксоных нь зайлшгүй шаардлагатай хүн амд чиглэсэн хэрэгцээг тодорхойлох үндсэн дээр хэрэгжих нийгмийн хамгаалал, түүнчлэн зах зээлийн нийгмийн хариуцлага, халамжийн холимог эдийн засаг зэрэг зарчмуудаар тодорхойлогдоно.

Хүснэгт 1. Нийгмийн хамгаалалт капитализмын гурван ертөнц. Э.Андерсений хэв маягчлал.

	Англо Саксоны	Эх газрын Европын	Умардын (Скандинавын)
Зах зээлээс үл хамаарах (зах зээлийн хэмнэлт, ширвэлтийн эсрэг хийгээд орлогогүйдлийн эсрэг арга хэмжээ-орлогыг нөхөн олгох, орлуулах арга хэмжээ, хувь хүний санхүүгийн баталгаажих хувь хэмжээ ⁵⁸)	Бага	Дунд зэрэг	Өндөр
Хэрэгцээтэй хэсэгт үзүүлэх халамжийн үйлчилгээнд өгөх ач холбогдол. Нийгмийн салбарын нийт зардалд халамж, асрамжийн үйлчилгээний хувь хэмжээ (резидуализм)	Хүчтэй	Хүчтэй	Сул
Хувьчлал (Зах зээлжсэн халамжийн үйлчилгээ ба даатгал-нийгмийн хамгааллын нийт зардалд ахмад настны болон эрүүл мэндийн хувийн хэвшлийн зардлын хэмжээ)	Хүчтэй	Дунд	Сул
Корпоратизм/этатизм -зорилтот бүлгээр нийгмийн	Сул	Хүчтэй	Сул

⁵⁸ Хувь хүнийг бусдаас санхүүгийн хувьд үл хараат байлгахад чиглэсэн тогтолцоог бүрдүүлэхийг нийгмийн хамгааллын судлалд нутаг усны хүмүүсээс үл хараат байлгахуй (dekommunalisierung), гэр бүлийн гишүүдээс үл хараат байлгахуй (defamilisierung) гэх мэтээр янз бүрээр нэрлэдэг. Гэвч эдгээр нь ерөнхийдөө зах зээлээс үл хамааруулах бодлогын тодорхой төрөл, хэлбэрүүд болдог.

хамгааллын үйлчилгээ ялгарах, нийгмийн үйлчилгээний байгууллага, албадуудаар дамжих тусламжийн үйлчилгээний хувь хэмжээ		
Нийгмийн баялгийг хуваарилах чадавхи (Татварын системийн өсөн нэмэгдэх түвшин)		
Бүрэн ажил эрхлэлтийг эрмэлзэх (Хөдөлмөр эрхлэлтийн идэвхитэй бодлогод зарцуулж буй төсөв, Ажилгүйдлийн түвшин, ажил эрхлэлтээр жигнэсэн)	Сул	Сул Хүчтэй

Эх сурвалж: J. Schmidt Wohlfahrtsstaaten im Vergleich: Soziale Sicherungssysteme in Europa. Organization, Finanzierung, Leistungen, Probleme. Leske-Kipladen 1996. Seite-57

Э.Андерсений нийгмийн хамгаалалт төрийн хэв маягчлал анхдагч бөгөөд шинэлэг байсан хэдий ч, судлаачдын зүгээс зарим шүүмжлэлтэй тулгарах болсон байна. Энэ нь юуны өмнө нийгмийн хамгааллын харьцуулсан судалгааны салбар цаашид хөгжиж ирсэнтэй, түүнчлэн дэлхийн улс орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжилд ахиц, дэвшил гарч, дэлхийн томоохон капиталист орнуудын бүл нэмэгдэх болсонтой, эцэст нь дэлхийн төмөр хөшиг нээгдэн, үзэл суртлын хэрэм унасанаар олон улсын дэг журамд шинэ хуваарь тогтсонтой тус тус холбоотой юм. Түүний бүтээлд шүүмжлэлтэй хандах болсон дараах талуудыг тэмдэглэж болно. Үүнд **нэгдүгээрт**, уламжлалт социаль бүтэцтэй, нийгмийн амьдралд гэр бүлийн учир холбогдол, нөлөө ихтэй европын өмнө зүгийн орнууд болох Испани, Португал, Грек, цаашилбал зарим талаар Итали зэрэг нь энэхүү хэв маягчлалын гадна үлдсэн, **хоёрдугаарт**, дэлхийн эдийн засагт өндөр байр суурь эзлэх болсон капиталист эдийн засаг бүхий азийн орнууд, тухайлбал япон, өмнөд солонгос, энэтхэг, цаашилбал азийн бар орнуудыг аль хэв маягт хамруулах нь хүндрэлтэй болсон, **гуравдугаарт**, мөнхүү дээр хэв маягчлалд хамрагдаагүй хуучин социалист дэглэмд байсан, төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж буй дунд болон зүүн европын орнуудын асуудал гарч ирсэн (Польш, Унгар, Орос болон бусад), **дөрөвдүгээрт**, ойрхи дорнотын улс орнууд мөнхүү нийгмийн хамгаалалт төрийн ямар хэв маягт багтах нь бүрхэг үлдсэн гэх мэтийг дурдах хэрэгтэй. (Г.Баэкер, Г.Наэгл болон бусад, 2005, 52)

Гэвч Э.Андерсений хэв маягчлал нийгмийн хамгааллын харьцуулсан судалгааны салбарт хүчин төгөлдөр, басхүү хамгийн нөлөө бүхий онол, аргазүйн тавилыг бий болгож чадсан юм. Учир нь нийгмийн хамгаалалт төрийн гурван ертөнц нь хамгийн суурь шинжтэй, явууртай ангилал гэж үзэж болох агаад учир юунд гэвэл нийгмийн хамгааллын институцчилэлд хамгийн гол нөлөө бүхий хүчин зүйлүүд болох улс төрийн үзэл баримтлал, үнэт зүйл зарчим, зах зээлд оролцох төрийн оролцоо, хөдөлмөрийн зах зээлийг зохицуулах арга хэлбэр, нийгмийн баталгааг хангах зарчим, механизм зэргийг аль нэг хэмжээгээр шалгуур үзүүлэлтэд тусган авсанд байна. Дэлхийн улс орнуудын шашны итгэл үнэмшил, газарзүйн байршил, хүн амын тоо, уламжлал зэргээс илүү дээрх хүчин зүйлүүд нь улс орнуудад нийгмийн хамгааллын ямар

тогтолцоо оршин байна, хүн амынхаа нийгмийн баталгааг хэрхэн хангаж байна, хамгаалалт төрийн ямар дэглэм тогтож байгаа зэрэгт шийдвэрлэх нөлөөтэй гэж хэлж болно.

Нийгмийн хамгааллын харьцуулсан шинжилгээний салбарт германы социологич Ф.Кауфманн, Ж.Шмит зэрэг судлаачид томоохон хувь нэмэр оруулжээ. Ф.Кауфманн "Нийгмийн хамгаалалт төрийн хувилбарууд" бүтээлдээ улс орнуудын төрийг тодорхой хэв маягчлалд оруулаагүй боловч, төр ба нийгэм, эдийн засаг ба үйлдвэрчний эвлэл, тухайн орны нийгмийн бодлогын түлхүүр чиглэл гэх мэтээр дэлхийн томоохон нийгмийн хамгаалалт төр улсууд болох Герман, Америк, Англи, Шведийн төр, засгийн газрын бодлого, тогтолцоог түүхэн харьцуулалтын замаар авч үзжээ. (Ф.Кауфманн, 2003: 17-19) Орчин үеийн харьцуулсан нийгмийн хамгаалал судлалд, төдийгүй ерөөс нийгмийн хамгааллын судалгаанд улс төрийн шинжлэх ухааны хүрээнд хэрэглэгддэг зарим нэг тулгуур ойлголтуудыг чухалчлан авч үздэг билээ. Эдгээр нь бүхэл улс орныг гол болгох полити (polity), улс төрийн бодлогуудыг агуулах политикс (politics), нийгэмд буй болсон тодорхой асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн полиси (policy) зэрэг болно. (Ж.Шмит, 2002: 70-71)

Андерсений хэв маягчлал цаашид гүнзгийрэн, түүнийг залгамжлагч барууны судлаачдын дунд улам боловсронгуй болж ирсэн билээ. Түүний хэв маягчлалын хүрээнд нэмэлт шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан, түүнчлэн улс төрийн системийн чиг үүрэг, үзэл суртал, үнэт зүйлсийн асуудлуудыг хөндөн тавьсанаар нийгмийн хамгаалалт төрийн судалгааны энэ талбарт үлэмж чухал зүйлүүдийг оруулж ирсэн байна. Төрийн зүгээс нийгмийн хамгааллын салбарт тогтоож буй дэглэм, хэв маягыг тодорхойлоход тухайн нийгэм дэх улс төрийн ноёлох үзэл суртал, соёлын үнэт зүйлс, оршин буй нийгмийн социаль бүтэц, түүнд төрийн зүгээс болон олон нийтийн санал бодлын зүгээс хандах хандлага, нийгэмд буй социаль зөрчил зэрэг асуудлууд ихээхэн чухал болохыг харж болно.

Хүснэгт 2. Нийгмийн хамгаалалт төрийн хэв маягууд

	Англо Саксоны	Эх газрын Европын	Умардын (Скандинавын)
Улс төрийн эдийн засаг	Либерализм (Зүүний либерализм ба лайссец фэйрэ)	Консерватизм (Корпоратизм ба, патернализм)	Социал демократизм, этатизм
Гол зорилго ба үнэт зүйл	Хувь хүний зах зээлийн чадавхи ба эрх чөлөө	Баталгаат байдал, сүбсиадаритет, Статусын ялгаа хадгалагдах ба иерархи	Зах зээлээс үл хамаарсан байдлыг дэмжих, Тэгш байдал, Баталгаат байдал
Нийгмийн болон хөдөлмөрийн бодлогын стратеги	Уян хатан байдал ба Хөдөлмөрийн зах зээлийн өсөлт	Ажил эрхлэлтэд баримжаалсан нийгмийн баталгаат байдал	Төрийн ба олон нийтийн үйлчилгээг бүтээх, багтаах ба хяналттай уян хатан байдал

Нийгмийн хамгааллын бүтээгдэхүүний гол фокус	Зах зээл	Гэр бүл	Улс орон
Хөгжлийн хил ба зөрчил	Нийгмийн дезинтеграци ба нийгмээс гадуурхагдсан ядуурлын тохиолдлууд (мөн ажилтай ядуучууд)	Орчин үежилт ба хүн амзүйн хямрал (хүн амзүйн хөгшрөлт)	Санхүүгийн (татварын эсэргүүцэл баялгын дайжилт) хямрал ба
Үйлчилгээний хэлбэр	Халамжийн үйлчилгээ ба хувийн хангамжийг дэмжих	Нийгмийн даатгал Нийгмийн халамж	Универсаль үйлчилгээ (Улсын иргэний хангамж)
Хуваарилалт	Бага	Өндөр (гэвч хүй элгэний түвшинд хэвтээ чиглэлд)	Өндөр (босоо дээрээс доош чиглэлд)
Жишиг улс	АНУ, Их Британи	Герман, Франц, Австри	Швед, Дани, Финлянд

Эх сурвалж: Carsten G. Ulrich, Soziologie des Wohlfahrtstaates. Eine Einfuehrung. Campus Verlag, Frankfurt in Main. 2005. Seite-52, Wohlfahrtsaaten. Krise und Reform. Metropolis Verlag. Marburg 1998. Seite-20

Нийгмийн хамгааллын харьцуулсан судалгааны аргазүй

Харьцуулсан нийгмийн хамгаалал судлалын салбарт Э.Андерсений хэв маягчлал ихээхэн урам зориг өгчээ. Судлаачдын энэ чиглэлийн зохиол бүтээлүүдээс харж байхад дэлхийн ул орнууд дахь нийгмийн хамгааллын дэглэмүүдийг судлахдаа хамгаалалт капитализмын гурван ертөнцөд баримжаалан тодорхойлох, эл эрдэмтний болон түүнийг залгамжлагчдын аргазүйд түшиглэх нь нийтлэг юм. Гэвч нийгмийн хамгааллын харьцуулсан шинжилгээ нь барууны судлаачдын дунд аргазүйн янз бүрийн тавилттайгаар хөгжиж ирсэн байдаг. Тухайлбал энэ талаар европын судлаачдын хамтын бүтээлд судалгааны өгөгдлийн шинж чанар, өгөгдөлд шинжилгээ хийж буй хандлага, шинжилгээний нэгж, нэгжийн тоо хэмжээ гэх мэт шалгуурын дагуу нийгмийн хамгааллын судалгааны тавилыг тодорхойлох оролдлого хийжээ. Үүнийг хэрхэн дүрсэлж болох талаар дараах хүснэгтээс харж болох юм.

Хүснэгт 3. Нийгмийн хамгааллын харьцуулсан судалгааны аргазүйн хандлагууд

	Мэдээлэл, өгөгдлийн шинж чанар	Мэдээлэл, өгөгдөлд шинжилгээ хийх хандлага	Шинжилгээний нэгж	Нэгжийн хэмжээ	Судалгааны зорилго
Борхерт	Чанар	Хөнгөн	Улс орнууд, төр засгийн газрууд	4	Дүрслэх
Иммерфал	Холимог	Хөнгөн	Улс орнууд, төр засгийн газрууд	1	Тодорхойлох
Роллер	Тоо	Хөнгөн	Хувь хүн, өрх гэрүүд	Төлөөлөх чадварт	Тайлбарлах

түшиглэсэн				
Клайнфэлд	Чанар	Гүнзгийрсэн	Улс орнууд, төр 1 засгийн газрууд	Дүрслэх
Шмит	Тоо	Хөнгөн	Улс орнууд, төр 2 засгийн газрууд	Тайлбарлах
Боммис	-	Хөнгөн	-	Мета түвшинд тайлбарлах
Мойга	Чанар	Хөнгөн	Улс орнууд, төр 1 засгийн газрууд	Дүрслэх, түүхчлэх
Плацер	Тоо	Хөнгөн	Улс орнууд, төр ЕХ-ы Улсууд засгийн газрууд	Дүрслэх
Буш	Тоо	Гүнзгийрсэн	Улс орнууд, төр ЕХ-ы Улсууд засгийн газрууд	Тодорхойлох

Эх сурвалж: Wohlfahrtsaat. Krise und Reform im Vergleich. Metropolis Verlag. Marburg 1998. Seite-26

Түүнчлэн нийгмийн хамгааллын харьцуулсан шинжилгээ нь шинжлэх ухааны онол аргазүйн сургуулийн (школын) хувьд үндсэндээ дөрвөн чиглэлд явагдаж байгаа талаар Манфред Шмид тэмдэглэсэн байдаг. Түүний үзсэнээр нийгмийн хамгааллын бодлогын нийгэм, эдийн засгийн хүчин зүйл болон үр нөлөө, үр дагаварыг тодорхойлох **нийгэм эдийн засгийн шинжилгээний сургууль** (гол төлөөлөгч нь Х.Виленски), нэг талаас орчин үеийн ардчилсан дэглэмийн үе дэх хөдөлмөр болон баялгийн хоорондох зөрчил, нөгөө талаас нийгмийн хамгаалалт төрийн зөрчилт талуудыг тодорхойлох **неомарксист төрийн онолын сургууль** (гол төлөөлөгч нь Ж.Стефенс, С.Оффе нар), уламжлалт нийгмийг (гэр бүл, хамаатан садны) халж буй болон орчин үеийн нийгмийн аж үйлдвэржилт, эдүүгээжилтийн сөрөг үр дагаваруудыг хөнгөвчлөх үүднээс нийгмийн хамгааллын институцийн өсөн томролт, чиг үүргийн өөрчлөлтийг тодорхойлох **макросоциологийн сургууль** (гол төлөөлөгч нь Ж.Албер, П.Флора), улс төрийн хүчин зүйл бүхий нийгэм, эдийн засгийн нөлөөлөл, шахалт хэрхэн төрөн гарч буй талаар, түүнчлэн нийгмийн бодлогын түвшин, хөгжлийн олон улсын түвшин дэх ялгааг тодорхойлох **улс төрийн институциональ сургууль** (гол төлөөлөгч нь Манфред Шмид, Э.Андерсен, Ж.Хиггинс) зэрэг болно. (М.Шмид, 1988. 140)

Харьцуулсан нийгмийн хамгаалал судлалын хүрээнд германы судлаач Ж. Шмитийн зураглан гаргасан аргазүйн ангиллууд басхүү ихээхэн соинрхол татдаг. Тэрээр нийгмийн хамгааллын харьцуулсан судалгааг дотор нь хувьсах хэмжигдэхүүний тоо болон судалж буй улс орнуудын буюу тохиолдлын тоонд харгалзуулан ангилсан байна.

Хүснэгт 4. Нийгмийн хамгааллын харьцуулсан судалгааны аргазүйн ялгаа

Судлан буй тохиолдлын тоо	
Бага	Их

Хувьсах хэмжигдэхүүний тоо	Бага	Кейс судалгаа (a)		Олон улсын харьцуулалт (b)	
	Их	Макро-түүхэн (c)	харьцуулалт	Макро (олон хэмжээний) харьцуулалт (d)	түмний статистик

Эх сурвалж: J. Schmitd Wohlfahrtstaaten im Vergleich: Soziale Sicherungssysteme in Europa : Organization, Finanzierung, Leistungen, Probleme. Leske-Kpladen 1996. 30

Нийгмийн хамгааллын харьцуулсан шинжилгээ нь юуны өмнө хоёр чиглэлээр хийгдэж болохыг энд харуулжээ. Эдгээр нь нэг талаас тухайн улс орны нийгмийн хамгааллын хүрэн дэх төрийн дэглэмийг түүхчлэн, түүхийн өөр өөр цаг үе дэх түүний мөн чанарыг харьцуулан шинжлэх боломжтой бол, нөгөө талаас өөр өөр улс орнуудын нийгмийн хамгаалалт төрийн бодлого, үйл ажиллагааг нэгэн цаг үеийнх нь байдлаар харьцуулан судлах аргазүй юм. Манай орны хувьд ерөөс нийгмийн хамгаалал судлал залуу байгаагийн улмаас нийгмийн хамгааллын харьцуулсан хүрээнд онцгойлоод авч үзэх судалгааны ажил, тэр дундаа Монголын нийгмийн хамгаалалт төрийг түүхэн болон бусад системтэй харьцуулсан ажил өнөө хир нь үгүй байна.

Товч дүгнэлт

Нийгмийн хамгаалал харьцуулсан судалгааны салбарт улс орнуудын нийгмийн хамгааллын тогтолцоо, төрийн нийгмийн хамгааллын бодлого, арга хэмжээг харьцуулан судлах чиглэл нь барууны орнуудад нэлээд өндөр түвшинд хүрсэн гэж хэлж болно. Харьцуулсан нийгмийн хамгааллын судалгааны салбарт анхны шанг татаж, хожмын судлаачдын үзэл санаа, бүтээлд ихээхэн хувьд нэмэр оруулсан хүн бол умардын социологич Э.Андерсен билээ. Түүний нийгмийн хамгаалалт төрийн хэв маягчлал нь шинжилгээний аргазүйн хувьд нийгмийн хамгааллын харьцуулсан судалгааны хөгжилд түлхэц өгч, орчин үеийн дэлхийн хөгжилтэй болон хөгжиж буй орнуудын нийгмийн хамгааллын тогтолцоог судлах аргазүйн нэгэн томоохон тулгуур болсоор байна.

Номзүй

F.X.Kaufmann. Varianten des Wohlfahrtstaates. Der deutsche Sozialstaat im internationalen Vergleich. 2003

Gerhard Baecker, Gerhard Naegele, Reinhard Bisping und andere. Sozial Politik und Soziale Lage im Deutschland, Band 1, Grundlagen. Arbeit, Einkommen, Finanzierung. 4 Auflage. Fachverlage Gmbn, Wiesbaden. 2008

J. Schmid Wohlfahrtstaaten im Vergleich: Soziale Sicherungssysteme in Europa : Organization, Finanzierung, Leistungen, Probleme. Leske-Kpladen. 1996

J. Schmid Wohlfahrtstaaten im Vergleich: Soziale Sicherungssysteme in Europa : Organization, Finanzierung, Leistungen, Probleme. Leske-Kpladen. 2002

Manfred Schmidt. Sozialpolitik. Historische Entwicklung und internationaler Vergleich. Opladen. 1983

Robert A. Goodin, Bruce Headey, Rood Muffels and Henk Jang Dirven. Real Worlds of Welfare Capitalism. Cambridge University Press. 1996

Wohlfahrtsaaten. Krise und Reform. Metropolis Verlag. Marburg 1998

Abstract

In this article will be considered patterns of welfare state of the world. The author analyses patterns of western distinguished researchers in the comparative social protection research field and tries to describe the main patterns of welfare state in Anglo Saxon, Continental European and Scandinavian countries. This article's main conclusion is focused on the serious influence of the welfare state pattern to the development of comparative social protection research.